



Үүсгэн байгуулагчийн бодрол

“Баярлалаа” хэмээх ганцхан үг

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

Living the Lotus
Vol. 200 (2022.05)

Ахлах редактор: Акагава Кэйичи
Орчуулсан: Ж.Гэрэлтуяа, Оюу-Эрдэнэ
Эхийг хянасан: Монголын РКК
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan
TEL: +81-3-5341-1124
FAX: +81-3-5341-1224
Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Хэрэв таны амнаас хаана ч, хэзээ ч, ямар ч үед хүн дуудахад “за, яасан бэ” гэсэн хариу, мөн “баярлалаа” хэмээх үгс төвөггүйхэн гардаг бол та бурханы шавь болох шалгуурт тэнцлээ гэсэн үг.

Ямар ч үед инээмсэглэхээ марталгүй, чанга, цовоо дуугаар бусдад хариу өгөхөөр сэтгэл шал өөр болдог. Ийм хандлага нь хөлөг онгоцны залуур мэт хүнийг аз жаргалаас аз жаргал руу чиглүүлдэг.

Цагаан лянхуа судар бидэнд энэ дэлхийд ар араасаа болж буй элдэв үйл явдлын юу нь хамгийн чухал болох, яагаад ийм зүйл болдог, түүнийг юунд тулгуурлан харахыг зааж, улмаар аливаа зүйлийг хэрхэн хүлээн авч, бусадтай хэрхэн харилцахыг, хүний амьдралын жинхэнэ утга учрыг заан сургадаг.

Ийм гайхамшигтай амьдралын замыг сурч мэдсэнээр сэтгэл зүрх тань өдөр бүр аз жаргал, талархлаар бялхдаг болох юм бол үүнийг бурханы гэгээрэл гэж хэлж болно гэж боддог.

“Аз жаргал гэдэг нь “баярлалаа” гэж хэлж чаддаг байхыг хэлнэ” гэж нэг хүн хэлж билээ. Талархаж мэддэг зүрх сэтгэл бол хүний хамгийн үнэт эрдэнэ юм.

«Үүсгэн байгуулагчийн үг» 10, Х194-195

Хүчлэн үл тэвчих “Хүлцэнгүй” 1-р хэсэг

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо



Хүн төрөлхийн хүлцэн тэвчих чадвартай

Хүмүүс бид зовлон зүдгүүр, тааламжгүй зүйлтэй тулгарахаараа нүд буруулмаар, зугтмаар санагддаг. Гэвч уулзан учрах хүмүүс, бэрхшээлээс зугтлаа гээд хаа холдох билээ.

31 жилийн өмнө буюу тус нийгэмлэгийн ерөнхийлөгчийн үүргийг залгамжлан авсны дараах жилээс авахуулаад 10 жилийн турш улс даяарх бүх гишүүдтэйгээ уулзах зорилготой “Садан төрлийн айлчлал” аяныг өрнүүлж байсан юм. Тэр үед өргөн уудам танхимын том тайзан дээр ганцаархнаа зогсоод арван мянга орчим хүний өмнө ярих тохиолдол ч байлаа. Нийтийн өмнө ярих дургүй миний хувьд “ямар хэцүү юм бэ” гээд зугтмаар санагдах үе нилээдгүй байсан.

Харин одоо нас ахисныхаа дараа эргээд харахаар хэцүү санагдаж байсан тэр туршлагын ачаар өнөөдрийн би байгаа гэж боддог. Нас ахихаар дургүй зүйлдээ дуртай болдог гэсэн үг биш боловч залуу байхад тэвчээр, тэсвэр хатуужил шаарддаг байсан зүйлүүдийг өөрөөр хүлээж авдаг болдгийг ид мэдэрч байна.

Өөрөөр хэлбэл уур ундуйцал хүргэмээр дургүй зүйлтэй тулгарсан ч бидний сэтгэлд түүнийг тэвчиж, хүлээн авч, бүр амьдралдаа хэрэгтэй зүйл болгон хувиргах чадвар байдаг гэсэн үг.

Хэмжээлшгүй утгасын тухай сударт “Догшин зантай нугуудад хүлцэнгүй сэтгэлийг төрүүлмүй” гэж гардаг. Бурханы сургаалыг сурсан хүн уур хилэн, үзэн ядах сэтгэлээ тэвчих хүлцэнгүй сэтгэлтэй болно гэсэн эрдэм буяныг эдэлнэ гэж сургасан хэсэг. Энэ хэсгийн “төрүүлмүй” гэдэг үг маш чухал утгыг агуулдаг гэж би боддог. Хүчээр уур уцаараа дарж тэвчих хэрэгтэй гэж сургалгүй, хүнд угийн бурханлаг чанар байдаг учраас аяндаа хүлээцтэй тэвчээртэй чанар “гарч ирнэ” гэж сургасан байгааг уншихаар сэтгэл уужирдаг юм. Тэгэхээр хүлцэнгүйн барамид нь хүчээр тэвшихийг сургадаг сургаал биш ажээ.

“Гэмт сэтгэл ба бодь сэтгэл нь нэг зоосны хоёр тал” гэж хэлдэг шиг хэн нэгнийг хараан зүхэх, нөхцөл байдлыг үзэн ядах сэтгэл нь нөгөө талаар бурханлаг чанарыг дуудан сэрээдэг. Бэрхшээл зовлон нь бид түүнийг даван туулах чадвартайг нотлох Бурханы тамгатай захиа байдаг. Тиймээс хичнээн

хүнд хэцүү зүйлтэй тулгарсан эерэгээр хүлээн авч нүүр тулах, хүлцэн тэвчих бурханлаг чанар байх аваас Бурханаас тийнхүү урам зориг өгч буйд талархах сэтгэл төрөх болно.

Хүлцэх нь хүлээн зөвшөөрөхтэй утга нэг

Нэг хүний “хүлцэн тэвчих гэдэг нь ойлгож хүлээн зөвшөөрсний үндсэн дээр тэвчихийг хэлнэ” гэж бичтэй би санал нийлдэг юм. Хэн нэгэнд уурлан үзэн ядах сэтгэл, дургүй зүйл, тааламжгүй мэдрэмжээ даван туулахын тулд, орчин тойрон нөхцөл байдлыг хүлээж авахын тулд эхлээд нөгөө хүнээ, тухайн үйл явдлыг ойлгож хүлээн зөвшөөрөх чухал. Ингэснээр хүлцэнгүйн барамидыг өдөр тутамдаа мэдээжийн зүйл мэт хэрэгжүүлж чаддаг болно.

“Би та нарыг хэзээ ч зэвүүцэхгүй, та нар бүгд бурханы хутаг олох болой” хэмээн залбиран мөргөх Насад Зэвүүцэхгүй бодисадва руу хүмүүс доромжлон дайрч давшлах боловч тэрээр “аль бүхнийг тэсвэрлэн хүлцжүхүй” гэж Цагаан лянхуа сударт гардаг. Хүмүүсийн бурханлаг чанарыг хүндлэн мөргөж, байгаагаар нь хүлээж авах сэтгэлийн үндсэн дээр хүлцэн тэвчиж буй түүний дүр төрх тус сударт маш чухал байр суурийг эзэлдэг.

Ойлгож хүлээн зөвшөөрөх нь сэтгэлд ч гэсэн амар байдаг. Дургүй зүйлээ хүчээр тэвчихээр хэцүү санагддаг. Харин тухайн зүйлийг байгаагаар нь хүлээгээд авчих юм бол сэтгэл хангалуун бус байдал, уур уцаар, үзэн ядалт зөөлөрч, хэцүү байна, зовлонтой байна гэсэн бодол ч багасдаг. Мөн хунтайж Шоотоку (574–622) “17 зүйлт үндсэн хууль”-д “Өөрийн бодол хүнтэй нийцэхгүй байлаа гээд уцаарлаж үл болно. Бүгд адилхан эрдэм мэдлэг, мунхагийг хослуулсан төгс бус эгэл хүмүүс билээ” гэж бичсэн байдаг. Үүний нэгэн адилаар энэ хүнд ч, надад ч гэсэн мэдлэг чадвар байхад мунхаг сэтгэл ч бий хэмээн хүлээн зөвшөөрөх юм бол уур уцаар аяндаа дарагдаад ирнэ.

Гэхдээ үүнийг шууд хэрэгжүүлж чадах үе байхад дээр өгүүлсэнчлэн цаг хугацаа өнгөрсний дараа эсвэл амьдралын туршлагаар дамжуулан хүлцэнгүй сэтгэлийг олж эзэмшсэнээ мэдрэх үе ч байх болов уу. Түүнчлэн хүлцэнгүйн барамид нь бодисадвагийн үйл гэдэг утгаараа бусдын төлөө гэсэн энэрэн нигүүлсэх утгыг давхар агуулдгийг мартаж болохгүй гэж бодож байна.

“Косей” сэтгүүл, 5-р сарын дугаар

Амьдралыг минь өөрчилсөн 3 учрал

Олон улсад сургаал түгээх хэлтсийн ажилтан

Хагивара Рёосүкэ

Энэхүү илтгэл нь 2022 оны 1 сарын 6-нд зохион байгуулагдсан “Транс Атлантикийн номын нөхөд” хэмээх хойд, өмнөд Америк, Европын хамтарсан онлайн хөтөлбөр дээр тавигдсан болно

Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Мөн шинэ оны мэнд хүргэе. Намайг Хагивара Рёосүкэ гэдэг. Би РКК нийгэмлэгийн Олон улсын хэлтэст ажилладаг. Өнөөг хүртэл тусалж дэмжиж байсан та бүхэнд баярлалаа. Би 2019 оны 12 сард Олон улсын хэлтэст томилогдон, өнгөрсөн оны 11 сар хүртэл хойд, өмнөд Америк болон Европын салбаруудыг хариуцаж байсан. Одоо Монгол, Оросын Сахалины салбарыг хариуцан ажиллаж байна. Үүнээс өмнө Гакурин сургуульд суралцсан.

Үүсгэн байгуулагч амьд ахуйдаа “Цагаан лянхуа судар бол учралын тухай, учралыг чухалчлахын тухай сургаал юм” гэж хэлсэн байдаг. Бидний амьдрал янз бүрийн үйл явдал, хүмүүс, учралуудаар дүүрэн байдаг. Бурханы сургаалд бидний эргэн тойронд байх эдгээр зүйлүүдийг “учрал” гэж нэрлэдэг. Үүсгэн байгуулагч дээрх үгээр дамжуулан “Хувь заяаны учрал”-ыг чухалчилж байхыг бидэнд заажээ гэж би боддог. Өнөөдөр өөрийн түүхийг, түүний дотроос амьдралд минь тохиолдсон 3 том учралын талаар, тэр учралаар дамжуулан хүртсэн ач буян, сурч мэдсэн зүйлийнхээ талаар ярья гэж бодож байна.

Ярианыхаа төгсгөлд тэдгээр учралууд дотроос миний анзаарсан хамгийн чухал зүйл юу байсан талаар ярих болно. Амьдралын туршлага багатай миний хувьд өөрийн сүсэг бишрэлийн тухай ярих боломж олдсонд туйлаас баярлаж байна. Та бүхэн таалан сонсоно уу.

Бурханы сургаалтай учруулсан хамгийн анхны учрал бол сэтгэл санааны өвчин байсан юм. Би буддын сургаалыг эрхэмлэн сүсэглэдэг гэр бүлд төрсөн. Аав маань Косей Кай байгууллагын ажилтан бөгөөд одоо Токио хотын Нэрима нийгэмлэгт алба хашдаг. Одоогоос 8 жилийн өмнө Олон улсын хэлтсийн дэд даргаар ажиллаж байсан учраас та бүхний олонх нь аавыг маань мэдэх байх. Ээж маань Сайтама мужийн Урава нийгэмлэгт салбарын

ахлагчийн үүрэг гүйцэтгэдэг ба эмээ маань ч бас нийгэмлэгт чухал үүргийг гүйцэтгэдэг байсан. Харин би их сургуульд орох хүртлээ шашин шүтлэгт ямар ч сонирхолгүй байсан юм. Ихэнх Япон хүмүүс шинэ үеийн шашинд шүүмжлэлтэй ханддаг учраас шашин шүтэхээс ичдэг бас мэдээж нийгэмлэгт бараг очдоггүй байсан.

Их сургуульд сурч байхдаа анх удаа нийгэмлэгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон маань Италийн Ром дахь Ватиканы хэвлэлийн албанд дадлагажигчаар ажилласан явдал байлаа. Тэнд “Косей” сонингийн салбар байдаг бөгөөд Мияхара Хироши гуай одоо ч



Хагивара Рёосүкэ

салбарын даргаар ажилладаг. Их сургуулийн 2-р курсийн зун Ромд аялаж байхдаа Мияхара гуайтай танилцсан ба тэр үед “Ватиканд надтай хамт ажиллаж үзэхгүй юм уу?” гэж хэлсэн юм. Итали хэл мэдэхгүй, хэвлэлийн ажлыг ч бас мэдэхгүй болохоор санаа зовж байсан ч нийгэмлэгийн Ром дахь төвийн дарга Мизүмо Кацүтошитой энэ талаар зөвлөж үзэв. Тэгтэл “Чадах эс чадахыг бодохоосоо илүү хиймээр байна уу үгүй юу гэдгээ л шийд” гэж зөвлөсөн юм. Улмаар би энэ ажлыг хийгээд үзэхээр шийдэж билээ.

Гэвч дадлагажигчаар явахад бэлдэж байхдаа сэтгэл түгших эмгэг туссан юм. Их сургуулийн амьдралд дасахгүй, сэтгэл санааны ядаргаа, бухимдалд автаж нэг л мэдэхэд ийм өвчин туссан байлаа. Өвчний улмаас гараа хэт их угааж, нэг юмыг олон дахин шалгадаг болж, сэтгэл санааны байдал ч тогтворгүй болсон. Хэн нэгэн хараад байгаа ч юм шиг хоосон бодлоос болж ямар нэг алдаа гаргачих вий гэсэн айдас түгшүүр байнга төрдөг байв.

Визний асуудлаас болоод дадлагаа хоёр хувааж хийсэн ба эхний удаагийн дадлагын үеэр ид өвчиндөө шаналж байсан юм. Орой болгон Мизүмо төвийн дарга, түүний эхнэр Юүкатай ярилцахад айдас түгшүүр арилдаг байсан ч төд удалгүй дараагийн сэтгэлийн зовнил, айдаст автдаг байлаа. Гэлээ ч төвийн дарга, түүний эхнэр хоёр намайг үргэлж сонсож, санаа тавьдаг байсан юм. Харин би өөрийгөө л арай ядан авч явж байв.

Эхний дадлагаа дуусгаад Японд буцаж ирэхэд сэтгэл санаа тогтвортой болж ирсэн. Гэвч тэр үед охин дүү маань сургуульдаа явахгүй байгааг мэдсэн юм. Нэг орой өрөөндөө уйлж байгаа дүүгээ хараад “Үүнд би буруутай. Би зөвхөн өөрийгөө л боддог байсан болохоор дүү маань ч сэтгэлийн тэнхээгүй болчихсон байна” гэж бодогдсон. Өмнө нь хэзээ ч мэдэрч байгаагүй их гэм буруутай мэдрэмж төрсөн. Тэр үед би дүүгийнхээ төлөө хүчтэй амьдрахгүй бол болохгүй юм байна гэж бодон хоёр дахь дадлагаа дүүгийнхээ төлөө сайн хийнэ гэж дотроо хатуу шийдсэн юм.

Дүүгийнхээ төлөө гэсэн сэтгэлээр дадлагаа хийж байтал өвчиндөө шаналах маань илт багасав. Тэгэхэд л анх “Бусдын төлөө амьдарснаар өөрийн зовлон үгүй болдог юм болов уу” гэж анзаарсан. Яг тэр үеэр Италид айлчилж ирсэн Гакүрин сургуулийн захирал асан Нивано Мүнэхиро гуайтай уулзах боломж олдсон юм. Уулзахаас 3 цагийн өмнө Мизүмо төвийн дарга гэнэт над руу залгаад “Рёосүкэ, өнөөдөр Мияхара даргын ажлын халааг авах уу гэж захирал чамаас асууна. Түүний ажлыг авна

гэдэг нь Японоос холдон насан туршдаа Италид амьдрана гэсэн үг гэдгийг ойлгох хэрэгтэй шүү. Хэрхэхээ сайтар бодож шийдээ гаргаарай, амжилт хүсье” гэж хэлсэн. Гуравхан цагийн дотор амьдралаа шийдчихгүй бол болохгүй гэж үү гэж бодогдов. Тэгээд уулзалтын өмнөхөн гэнэт өөрийн хиймээр байгаа зүйлээс илүү бусдын төлөө ямар нэг зүйл хийх нь чухал биш гэж үү. Ингэх нь миний хувьд аз жаргалтай амьдралын замнал гэж бодсон. Тэгээд захиралд “Бусдын төлөө үйл юм бол би хиймээр байна” гэж хэлэхэд тэрээр миний бодлыг ойлгон хүлээн авч Гакүрин сургуульд орохыг зөвлөсөн юм. Би ийм шалтгаанаар Гакүринд элсэн орж жинхэнээсээ Косей Кай нийгэмлэгийн сүсэг бишрэлтэй нүүр тулсан билээ.

Ийнхүү сэтгэл түгших эмгэг өвчинтэй учирснаар бусдын төлөө амьдрахын чухлыг ойлгож, сүсэг бишрэлийн хүч, нийгэмлэгийн санга нарын гайхамшигийг мэдэрсэн юм. Хэдий өвчин эмгэгээр дамжуулсан ч гэлээ энэ явдал бурханы төлөвлөгөө байсан ч юм болов уу гэж бодогддог. Бурхан “Рёосүкэ, өөрийгөө л бодоод байлгүй эргэн тойрныхоо хүмүүсийн төлөө боддог хүн болох хэрэгтэй” гэж надад дамжуулахыг хүссэн юм болов уу гэж боддог. Өвчинөөр шаналж үзэж байж л сая бодисадва хүний амьдралыг ойлгож, сүсэг бишрэлийн чухлыг анзаарсан билээ.

Амьдралыг минь өөрчилчөн хоёр дахь учрал нь “Урам хугарал” байсан юм. Дээр өгүүлсэнчлэн би Гакүрин сургуульд элсэн орлоо. Мияхара даргын ажлыг авахын тулд католик шашныг судлах шаардлагатай байсан учраас Гакүринд Цагаан лянхуа судрыг суралцсаны дараа ажилтны хувиар Итали руу сурахаар явахыг маш их хүсч байв.

Гакүринд би гайхалтай олон зүйлийг сурсан. Цагаан лянхуа судар, Үүсгэн байгуулагчийн сургаалыг судар номоос сурахаас гадна өдөр тутамдаа хэрэгжүүлэн сурсан. Бас эрхэм сайхан нөхөдтэй учирсан. Гэвч сэтгэлийн минь гүнд гадаадад сурахын тулд л Гакүринд сурч байна гэсэн бодол хүчтэй байсан тул тухайн үед би тэрхүү зорилгынхоо төлөө бүхнээ зориулж байлаа. Одоо эргээд бодоход бусдын төлөө гадаадад суралцах мөрөөдөл маань нэг л мэдэхэд өөрийн хүслийг биелүүлэх мөрөөдөл болж хувирсан байсан.

Гакүрин сургуулийг төгстөл намайг гадаад руу явуулалгүй Олон улсын хэлтэст хуваарилчихав. Үнэнийг хэлэхэд тэр үед Гакүринд суралцсан 3 жил юуны төлөө байсан юм бэ? гэж бодогдсон. Тэр шийдвэрийг хүлээж авч чадахгүй, сургуулиасаа гарч өөр аргаар Итали явах тухай хүртэл бодсон гээч.

Төгсөгчдийг хуваарилсаны маргааш 11 сарын 15-ны өдөр буюу Үүсгэн байгуулагчийн төрсөн

Spiritual Journey

өдөр ёслолын үйл ажиллагаа зохион байгуулах ажлаар удирдах төвд очлоо. Өглөө нь Нивано захирлаас “Чамд тусалж чадаагүйдээ харамсаж байна. Гэвч энэ учралыг үнэ цэнэтэй зүйл болгох уу эсвэл ямар ч утга учиргүй зүйл болгох уу гэдэг үнэн хэрэгтээ чамаас л шалтгаална. Хойшид ч хамтдаа бурханы үйлд шамдацгаая” гэсэн цахилгаан шуудан ирсэн юм.

Төрсөн өдрийн ёслолын ажиллагаа эхлэн маш завгүй байсан боловч ТУЗ-ын дарга Кавабатагийн мэндчилгээг сонсож чадсан. Тэрээр Үүсгэн байгуулагчаас хамгийн сүүлд авсан удирдамжийн талаар ийнхүү ярьсан юм. “Оноогдсон үүргээ биелүүлэх эс биелүүлэх, чадах эс чадах нь тийм ч чухал биш. Харин энэ бол бурханы өгсөн үүрэг учраас яаж ийгээд биелүүлбэ гэсэн чин сэтгэлээр бүх хүчээ дайчлан хичээж ажилдаа шамдах нь л чухал. Үүнийг л сэтгэлдээ хатуу шийдэхэд болно. Бурхан ингэж сэтгэлдээ чанд шийдсэн хүнийг л тосон хүлээж байдаг. Энэ удаа энэ ажлыг хийгээд үз. Тэгвэл чамд тохирох дараагийн ажил үүргийг бэлдэж өгнө. Тийм учраас урдах ажлаа чин сэтгэлээсээ хийцгээе.”

Үүнийг сонсох үед Үүсгэн байгуулагч надад хандан хэлж буй мэт мэдрэмж төрөн нулимс асгарав. Ёслолын ажиллагаа дууссаны дараа яриагаа дөнгөж дуусгаад байсан Кавабата дарга, түүний нарийн бичигтэй уулзсан юм. Нарийн бичиг нь намайг “Энэ бол Олон улсын хэлтэст томилогдсон Хагивара” танилцуулахад “Аан тийм үү, хичээгээрэй, амжилт хүсье” гэж урам өгсөн юм.

Олон улсын хэлтэст томилогдоод одоо 2 жил болж байна. Хэдий коронагийн нөхцөл байдал үргэлжилсээр байгаа ч олон номын анд нөхөдтэй учирч, ажлаа бахдалтайгаар хийж явна. Гадаадад сурах мөрөөдөл минь биелээгүй тэр үед эхэндээ урам хугарч ирээдүй маань бүрхэг байсан ч одоо бол энд ажиллаж байгаадаа маш их баяртай байна. Учир нь салбаруудын үйл ажиллагаанд оролцон, дэлхий даяарх номын анд нөхөдтэйгөө уулзаж, хэн нэгэнд хэрэгтэй үйл хийдэг болохоор тэр юм. Өмнө нь “Гадаадад сурах нь л миний хүссэн амьдрал” гэж боддог байсан бол одоо өөрт тохирсон сайхан амьдралд шинээр төрсөн юм шиг амьдарч байна.

Нэгэн өдөр хамаатантайгаа уулзаад Косей Кай нийгэмлэгийн тухай ярьж өгсөн юм. Нийгэмлэгт тийм ч дуртай биш тэрээр миний ажлын талаар янз бүрийн шүүмж санал хэлсэн. Албан байгууллага юм хойно янз бүрийн асуудал байдаг ч би Косей Кай нийгэмлэгт

дуртай, ажилдаа дуртай, номын анд нартаа хайртай учраас энд ажиллаж байгаагаа ойлгосон. Гадаадад сурч чадаагүй юм чинь нийгэмлэгээс гаръя гэж ч бодож байсан удаатай. Гэхдээ ингэж урам зоригийг минь хугталсан учрал миний хувьд юу хамгийн чухал болохыг, бурханы нүдээр харах юм бол хүний амьдралын хамгийн чухал зүйл юу болохыг анзаарч ойлгоход шаардлагатай учрал байсан юм байна гэж боддог болсон.

Гурав дахь учрал бол ахмад ажилтан болох аавтай учирсан учрал юм. Дээр өгүүлсэнчлэн аав маань Косей Кай нийгэмлэгийн ажилтан. Тэрээр нийгэмлэгийн тэргүүн болох хүртлээ Олон улсын хэлтэст ажиллаж байсан. Надаас яг 30 жилийн өмнө аав маань Гакурин сургуулийг төгсөж, 20 жилийн турш гадаадад сургаал түгээн ажилласан. Түүний улбаагаар би Германы Франкфуртад төрж, 2-оос 6 насандаа Английн Оксфордод өсч том болсон.

Би ааваасаа үлгэр дууриал авч ирсэн болохоор Олон улсын хэлтэст ажиллахыг сонирхох болсон юм. Уг хэлтэст ажиллаж байсан үеийн аавыгаа харж байхдаа дэлхий ертөнцийг тойрч буй ааваараа бахархаж хүндэлдэг байлаа. Ялангуяа Гакуринд элсэн орж, нийгэмлэгийн ажилтан болчихоод тэрхүү бахархал маань улам их болж аавынхаа олон сайхан агуу чанарыг олж хардаг болсон. Гакуринд байхдаа ч “Аав минь байсан бол юу гэж бодох байсан бол? гэх мэтээр аавынхаа орон зайг маш ихээр мэдэрдэг байсан. Нөгөөтэйгүүр ажилтан болчихоод аавынхаа хаана ч хүрэхгүй юм байна гэж өөрийгөө их чамладаг байлаа. Аавыгаа давж гарах нь байтугай хаана нь ч хүрч чадахгүй гэж боддог байв. Гакуриныг төгсөхийн өмнө ерөнхийлөгчийн гэрт оройн зоог барьдаг сайхан уламжлал байдаг. Төгсөхөөс нэлээн хэдэн өдрийн өмнө ангийнхан болон ажилтнуудтай хамт ерөнхийлөгчийн гэрт очиход биднийг маш сайхан хүлээн авч дайлж цайлж билээ. Тэр орой ханан дээрх Үүсгэн байгуулагчийн зургийг олж хараад гэнэт “Нивано ерөнхийлөгч Үүсгэн байгуулагч аавыгаа юу гэж боддог байсан бол?” гэж бодогдсон юм.

Оройн зоогийн төгсгөлд ерөнхийлөгч хаалтын үг хэлэх гэж байхад энэ асуултаа заавал асуумаар санагдан гараа өргөв. “Би аавыгаа хүндлэхийн хажуугаар өөрийгөө түүнтэй харьцуулан их чамладаг. Харин та өөрийн эцэг Үүсгэн байгуулагчийг юу гэж боддог байсан бэ?” гэж асуув. Ерөнхийлөгч шуудхан л “Илүү байж чадахгүй бол хөгжихгүй” гэж хэлээд “Ядаж 0,1 хувиар ч

Spiritual Journey

боловч илүү бай. Хийх ёстой ажил үүргээ илүү сайн хийж гүйцэтгэ. Хэрэв чи илүү байж чадахгүй бол хүн төрөлхтөнд өөрийн хувь нэмрээ оруулж чадахгүй” хэмээн үргэлжлүүлэн ярив. Аавыгаа хэзээ ч гүйцэхгүй гэж боддог байсан би гэнэтийн ийм хариулт сонсоод “Илүү байж давж гарах” гэж чухам юу гэсэн үг юм бол гэдгийг үнэндээ сайн ойлгоогүй. Гэтэл оройн зоогийн дараа тэнд байсан сургуулийн дэд захирал “Нивано ерөнхийлөгч бол Үүсгэн байгуулагчаас илүү байж чадсан хүн” гэж хэлсэн юм.

Ерөнхийлөгч тэр үед надад амьдралын минь зорилгыг тодорхой хэлж өгсөн юм байна гэж одоо боддог. Ерөнхийлөгч надад ааваасаа “илүү гарах”-ын тулд явсан зам мөрийг нь араас нь дагаад яваарай гэж хэлж зааж өгсөн юм шиг санагдаж байна. Рисшо Косей Кай байгууллагад ажиллахаас өмнө болон дараах аавын тухай бодол, харилцаа маань өөрчлөгдсөн ч ахмад ажилтан болох аавтай учирсан учрал минь надад өдөр тутмын ажлыг давж гарах хөдөлгүүр хүч болдог.

Энэ хүртэл би өөрийн амьдралын гурван том учралын талаар ярилаа. Бурхан биднийг маш олон төрлийн учрал тохиол хувь төөрөг, заримдаа таагүй гэмээр зүйлтэй ч учруулдаг. Цагаан лянхуа судрын Түүнчлэн ирсэний насны хэмжээ бүлэгт Буддагийн доорх сургаал бий. “Язгууртны олон хөвгүүд ээ, Түүнчлэн Ирсэний номлосон судар ном болбоос бүгдээр амьтныг гэтэлгэхүйн тулд бүлгээ. Эс бөгөөс өөрийн биеийг үгүүлэх ба эс бөгөөс бусдын биеийг үгүүлэх ба эс бөгөөс өөрийн биеийг үзүүлэх ба эс бөгөөс бусдын биеийг үзүүлэх ба эс бөгөөс өөрийн үйлийг үзүүлэх ба эс бөгөөс бусдын үйлийг үзүүлмүй.” хэмээсэн байдаг.

“Өөрийн бие”, “өөрийн үйл” гэдэг нь бидэнд таатай эерэг зүйлийг илэрхийлдэг бол “бусдын бие”, “бусдын үйл” гэдэг нь эсрэгээрээ таагүй сөрөг зүйл гэсэн утгатай. Бурхан биднийг таатай, таагүй янз бүрийн зүйлтэй учруулан гэгээрэл рүү ойртуулж байдаг гэсэн утгатай сургаал. Энэ сургаал шиг би амьдралынхаа гурван учрал тохиолоор дамжуулан аливаа зүйлийг бурханы өнцгөөр харахыг ухаарсан. Гэхдээ Бурханы хайрласан учрал тохиол бүрийн учир утгыг би ганцаархнаа ойлгож ухаарах боломжгүй байсан.

Энэхүү гурван учралд нийтлэг нэг зүйл бий. Тэр бол эргэн тойрон дахь номын анд нарынхаа ачаар би учрал тохиолын мөн чанарыг ойлгон анзаарч чадсан явдал юм. Өнөөдөр өөрийн туршлагаа эргэн харахад Мизүмо дарга, түүний эхнэр, охин дүү, Мүнэхиро сургуулийн захирал,

эцэг эхийн маань нэр хүнд, мөн Нивано ерөнхийлөгч, Үүсгэн байгуулагчийн хэлсэн үгс гээд маш олон зүйл сэтгэлд минь бууж байна. Энэ олон хүмүүсийн ачаар таагүй зүйл мэт санагдаж байсан учралууд үнэндээ надад шаардлагатай байжээ гэдгийг ойлгосон. Номын анд нар байсан учраас л би Бурханы үзэл санааг ухаарч, алив учралыг утга учиртай зүйл болгон хүлээж авч чадсан гэж боддог.

Шинэ он эхэлж байна. Өнөөг хүртэл тусалж дэмжиж байсан бүх номын нөхөддөө баярлалаа гэж хэлмээр байна. Цаашид ч та бүхнээс заавар зөвлөгөө авч, учралыг эрхэмлэж, сүсэгтэн хүний хувиар сургаал номын зам мөрөөр алхах болно. Бас би өөрөө ч сайн номын анд нөхөр болохын төлөө чадах чинээгээрээ хичээх болно. Анхаарал тавьсанд баярлалаа.



Хагивара Рёосүкэ аавын хамт

Рисшо Косей Кай Нийгэмлэг (Зурагт ном)


Үүсгэн байгуулагчийн намтар ба Рисшо Косей Кай нийгэмлэгийн түүх

Нивано ерөнхийлөгчийн сургаал

Нивано ерөнхийлөгч ямар ч хүн, хэзээ ч, хаана ч хийх боломжтой “Амьдралын гурван дадал”-ыг хэрэгжүүлэхийг бидэнд уриалдаг.

1. Өглөө бусадтай мэндэлж байя
2. Хэн нэгэн дуудахад “за” гэж тодорхой хариу хэлдэг байя
3. Суусан сандлаа заавал буцаан байранд нь тавьж, гутлаа зэрэгцүүлэн тавьж хэвшицгээе

Эдгээрийг өнөөдрөөс эхлэн гэртээ болон сургууль дээрээ хэрэгжүүлж үзээрэй. Сэтгэл сэргэж өөдрөг болно гэдэгт итгэлтэй байна.



Бяцхан мэдлэг

“Амьдралын гурван дадал” нь философич, сурган хүмүүжүүлэгч Мори Нобүзогийн дэвшүүлсэн “Хүмүүжлийн гурван зарчим”-аас улбаатай гэдэг. Мори гуай бол дайны дараа Японы боловсролын салбарт томоохон нөлөө үзүүлсэн хүн юм.

Удаах ерөнхийлөгч Коошоо



Коошоо багш 1968 онд Токио хотын Сүгинами дүүрэгт Нивано ерөнхийлөгчийн ууган охин болон мэндэлжээ. Их сургуулиа төгссөний дараа Рисшо Косей Кай нийгэмлэгийн хүний нөөцийн боловсролын байгууллага болох Гакурин сургуульд элсэн орж буддын шашнаас авахуулаад шашны талаар мөн нийгэмлэгийн сургаал түүний ач холбогдол зэргийг сурч судалжээ. Одоо нийгэмлэгийн үйл ажиллагаанд оролцож, дараагийн ерөнхийлөгч болох дадлага туршлага хуримтлуулж байна.

Мөн 4 хүүхдийн ээж бөгөөд халуун дулаан гэр бүлийг бий болгожээ. Тэрээр нүүр дүүрэн инээмсэглэл, найрсаг зан чанараараа нийгэмлэгийн гишүүдийн хайр хүндэтгэлийг хүлээдэг.

Бяцхан мэдлэг

Коошоо багш 1995 онд нөхөр Мүнэхиротойгоо гэрлэсэн. Ариун ордонд болсон гэрлэх ёслолд Японы өнцөг булан бүрээс 9000 гаруй гишүүд оролцжээ.

Хүлцэнгүй сэтгэл

Шинэхэн өвс ногоо ургаж нүд баясгасан тавдугаар сар ирлээ. Энэ сарын сургаалаар Зургаан барамидын “Хүлцэнгүйн барамид”-ын талаар сурах ба удаан хугацаанд коронаг тэсч ирсэн бидний хувьд яг тохирсон сэдэв мэт.

“Хүчлэн тэвчихгүй байх” гэсэн гарчигтай энэ удаагийн айлдвараар дамжуулан гүнзгий утга санаатай энэхүү үгэнд агуулагдах Нивано ерөнхийлөгчийн гүн бодлыг уншиж хүлцэнгүйн барамидын утгыг Үүсгэн байгуулагчийн «Лянхуан гурамсан судрын шинэ тайлбар» номноос дахин нэг удаа хайж үзлээ. Тайлбарт “өөрт сэтгэл санааны болон эд материалын хохирол учруулсан ч уужуу сэтгэлээр хандах” мөн “бусдад хичнээн хүндлэгдэж сайшаагдсан ч онгирч бардамналгүй ямагт тайван дөлгөөн байх” гэсэн утгатай гэж бичжээ.


Мөн Нивано ерөнхийлөгч үүрэг залгамжлан авсан тухайн үед тэвчээр шаардах зүйл олон байсан хэдий ч цаг хугацаа он жилүүд өнгөрөхийн хэрээр хүлээцтэй, тэвчээртэй чанар сууж, аливаа асуудлыг эерэгээр шийдэж чаддаг болсон талаараа бидэнтэй хуваалцсан байна. Зовлон бэрхшээлтэй учирсан ч түүнээсээ суралцаж, анхааралтай эргэцүүлэн бодсоноор зовлонг хүлээн авах сэтгэлийн хат сууж, зовлонг хүлээн зөвшөөрснөөр амар амгалан ирдэг болохыг хэн хүнгүй амьдралынхаа туршлагаар ойлгож ухаарвал сайхансан.

Дэлхий даяар зовлон бэрхшээл дүүрэн байгаа энэ цаг үе нь “хүлцэн тэвчих” ухааныг өөртөө суулгах маш сайхан боломж ч байж болох юм.

Кэйичи Акагава



Rissho Kosei-kai: A Global Buddhist Movement



Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, USA
 TEL: 1-808-455-3212 FAX: 1-808-455-4633
 Email: sangha@rkhawaii.org URL: <http://www.rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1809 Nani Street, Wailuku, HI 96793, USA
 TEL: 1-808-242-6175 FAX: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, USA
 TEL: 1-808-325-0015 FAX: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, USA
 TEL: 1-323-269-4741 FAX: 1-323-269-4567
 Email: rk-la@sbcglobal.net URL: <http://www.rkina.org/losangeles.html>

Please contact Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

- Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado**
- Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas**

Rissho Kosei-kai of San Francisco

(Address) 1031 Valencia Way, Pacifica, CA 94044, USA
 (Mail) POBox 778, Pacifica, CA 94044, USA
 TEL: 1-650-359-6951 Email: lotusbuddhist@gmail.com
 URL: <https://sf-buddhism.org/>

Please contact Rissho Kosei-kai of San Francisco

- Rissho Kosei-kai of Sacramento**
- Rissho Kosei-kai of San Jose**

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, USA
 TEL: 1-212-867-5677 Email: rky39@gmail.com URL: <http://rk-ny.org>

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, USA
 TEL: 1-773-842-5654
 Email: murakami4838@aol.com URL: <http://rkchi.org>

Rissho Kosei-kai of Fort Myers

URL: <http://www.rkftmyersbuddhism.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

(Address) 2745 N.W. 40th St., Oklahoma City, OK 73112, USA
 (Mail) POBox 57138, Oklahoma City, OK 73157, USA
 TEL: 1-405-943-5030 FAX: 1-405-943-5303
 Email: rkokdc@gmail.com URL: <http://www.rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

617 Kling Drive, Dayton, OH 45419, USA
 URL: <http://www.rkina-dayton.com>

The Buddhist Center Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First St., Suite #1, Los Angeles, CA 90033, USA
 TEL: 1-323-262-4430 FAX: 1-323-269-4567
 Email: info@rkina.org
 URL: <https://www.buddhistcenter-rkina.org>

Rissho Kosei-kai of Vancouver

Please contact RKINA

Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

(Address) 6083 Babcock Road, San Antonio, TX 78240, USA
 (Mail) POBox 692148, San Antonio, TX 78249, USA
 TEL: 1-210-558-4430 FAX: 1-210-696-7745
 Email: dharmasanantonio@gmail.com
 URL: <http://rksabuddhistcenter.org>

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, USA
 TEL: 1-253-945-0024 Email: rkseattlewashington@gmail.com
 URL: <http://buddhistlearningcenter.org>

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP, CEP 04116-060, Brasil
 TEL: 55-11-5549-4446, 55-11-5573-8377
 Email: risho@rkk.org.br URL: <http://www.rkk.org.br>

在家佛教韓國立正佼成會 Korean Rissho Kosei-kai
〒 04420 大韓民國 SEOUL 特別市龍山區漢南大路 8 路 6-3
6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea
TEL: 82-2-796-5571 FAX: 82-2-796-1696

**在家佛教韓國立正佼成會釜山支部
Korean Rissho Kosei-kai of Busan**
〒 48460 大韓民國釜山廣域市南區水營路 174, 3F
3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
TEL: 82-51-643-5571 FAX: 82-51-643-5572

社團法人 在家佛教立正佼成會 Rissho Kosei-kai of Taipei
台灣台北市中正區衡陽路 10 號富群資訊大廈 4 樓
4F, No. 10, Hengyang Road, Jhongheng District, Taipei City 100, Taiwan
TEL: 886-2-2381-1632, 886-2-2381-1633 FAX: 886-2-2331-3433

台南市在家佛教立正佼成會 Rissho Kosei-kai of Tainan
台灣台南市東區崇明 23 街 45 號
No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701, Taiwan
TEL: 886-6-289-1478 FAX: 886-6-289-1488
Email: koseikaitainan@gmail.com

Rissho Kosei-kai South Asia Division

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Kathmandu
Ward No. 3, Jhamsikhel, Sanepa-1, Lalitpur, Kathmandu, Nepal

Rissho Kosei-kai Society of Kolkata
89 Srirampur Road (VIP), Garia, Kolkata 700084, India

Rissho Kosei-kai of Kolkata North
AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya Dharma Center
Ambedkar Nagar, West Police Line Road, Rampur, Gaya-823001,
Bihar, India

Rissho Kosei-kai of Patna Dharma Center
Please contact Rissho Kosei-kai Society of Kolkata

Rissho Kosei-kai of Central Delhi
77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar,
New Delhi 110060, India

Rissho Kosei-kai of Singapore
Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai of Phnom Penh
W.C. 73, Toul Sampaov Village, Sangkat Toul Sangke, Khan Reouseykeo,
Phnom Penh, Cambodia

RKISA Rissho Kosei-kai International of South Asia
Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Bangkok
Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8216 FAX: 66-2-716-8218 Email: info.thairissho@gmail.com

Rissho Kosei Dhamma Foundation
No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka
TEL: 94-11-2982406 FAX: 94-11-2982405

Rissho Kosei-kai of Polonnaruwa
Please contact Rissho Kosei Dhamma Foundation

Rissho Kosei-kai Bangladesh
85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
TEL: 880-2-41360470

Rissho Kosei-kai Mayani
Mayani Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Damdama
Damdama Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Satbaria
Village: Satbaria Bepari Para, Chandanaih, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Chendhirpuni
Village: Chendhirpuni, P.O.: Adhunogar, P.S.: Lohagara, Chittagong,
Bangladesh

Rissho Kosei-kai Raozan
Dakkhin Para, Ramzan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Laksham
Village: Dhupchor, Laksham, Comilla, Bangladesh

Rissho Kosei-kai Dhaka North
408/8 DOSH, Road No 7 (West), Baridhara, Dhaka, Bangladesh

Rissho Kosei-kai Cox's Bazar
Ume Burmize Market, Tekpara, Sadar, Cox's Bazar, Bangladesh

Please contact Rissho Kosei-kai Bangladesh

Rissho Kosei-kai Patiya
Rissho Kosei-kai Ramu
Rissho Kosei-kai Aburkhill

Buddiyskiy khram "Lotos"
4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk 693005, Russia
TEL: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai of Hong Kong
Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point, Hong Kong, China

Rissho Kosei-kai Friends in Shanghai
Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai of Ulaanbaatar
(Address) 15F Express Tower, Peace avenue, khoroo-1, Chingeltei district,
Ulaanbaatar 15160, Mongolia
(Mail) POBox 1364, Ulaanbaatar-15160, Mongolia
TEL: 976-70006960 Email: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Erdenet
Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai di Roma
Via Torino, 29, 00184 Roma, Italia
TEL/FAX: 39-06-48913949 Email: roma@rk-euro.org

Please contact Rissho Kosei-kai di Rome

Rissho Kosei-kai of Paris
Rissho Kosei-kai of Venezia

Rissho Kosei-kai of the UK
29 Ashbourne Road, London W5 3ED, UK
TEL: 44-20-8933-3247 Email: info@rkuk.org URL: <https://www.rkuk.org>
Facebook: <https://www.facebook.com/rkuk.official>
Twitter: https://twitter.com/rkuk_official
Instagram: https://www.instagram.com/rkuk_official

Rissho Kosei-kai International Buddhist Congregation (IBC)
166-8537 東京都杉並区和田 2-7-1 普門メディアセンター 3F
Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537, Japan
TEL: 03-5341-1230 FAX: 03-5341-1224 URL: <http://www.ibt-rk.org>